



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 5/63

Хэрлэн сум

Л.Дугарыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйл, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл", Засгийн газрын 2022 оны "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтаар баталсан "Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам", 4 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам", аймгийн Засаг даргын 2022 оны "Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай" Б/34 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ламзавын Дугарыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн жижүүрээр 2022 оны 7 дугаар сарын 01-ээс томилсугай.

2. Л.Дугарын сарын үндсэн цалинг ТҮ-1 зэрэглэлээр тогтоон, 523,405 (таван зуун хорин гурван мянга дөрвөн зуун тав) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 25 хувиар, ур чадварын нэмэгдлийг 25 хувиар тооцож тус тус олгохыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3. Хөдөлмөрийн гэрээ, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Л.Дугарт үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ТАНБААТАР



231030364